



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 92

Атгал

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн "Алим, усан үзэм, жимс жимсгэнэ хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган, улс, орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс бүрдүүлж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, хэрэгжилтийн явцыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга Ю.Амгаланбаатард даалгасугай.

ДАРГА



А. ДЭЛГЭРЖАРГАЛ

"АЛИМ, УСАН ҮЗЭМ, ЖИМС ЖИМСГЭНЭ" ХӨТӨЛБӨР

Нэг. Жимс, жимсгэний хэрэглээ, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Жимс, жимсгэнэ нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, сахар, эрдсийн элемент болон биологийн идэвхт бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн төдийгүй бут сөөг нь ойн зураас, ногоон байгууламж байгуулах замаар хөрс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, элсний нүүдлийг сааруулахад хамгаалалт болдог олон талын ашиг тустай.

Манай оронд 60 гаруй зүйлийн зэрлэг жимс, жимсгэнэ ургаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоогоор насанд хүрсэн хүн жилд дунджаар 87.6 кг, өдөрт 240 гр жимс, жимсгэнэ хэрэглэх нь зохистой гэж үздэг. Манай улсын нэг хүн 1990 онд 12 кг жимс, жимсгэнэ хэрэглэж байсан бол 2007 онд 8.4 кг болж буурсны зэрэгцээ чанарын баталгаагүй импортын жимсийг ихээр хэрэглэж байна. Сүүлийн жилүүдэд жимс, жимсгэний хэрэгцээ огцом өсч, байгалийн жимсийг олон хэлбэрээр ашиглаж байгаа ч, нөөцийг нь арвижуулах асуудал хоцорч байна. 2009 оны байдлаар улсын хэмжээнд 1200 га талбайд жимс, жимсгэнэ тариалж байгаагийн 80 гаруй хувийг чацаргана эзэлж байгаа бол манай аймгийн тухайд ч энэ үзүүлэлт адилхан байна.

Тариалж буй жимс жимсгэний нэр төрлийг олшруулах, тухайн орон нутгийн онцлог тохирсон жимс тариалах асуудлыг шийдвэрлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршиж байна.

Алим нь бусад жимсэнд байдаггүй олон сайн шинж чанараар тодорхойлогдох бөгөөд ялангуяа жимс нь хадгалалтыг маш сайн даадаг, шинэ жимсийг нь олон сарын туршид хэрэглэж болдог. Жимс нь аскорбины хүчлээр баялаг (30-42мг%), мөн полифенолыг ихээр (300-450мг%) агуулдаг, эмчилгээ сувилгааны өндөр ач холбогдолтой зэрэг олон давуу талтай.

Манай улсад жилд импортоор 19.0 мянган тонн жимс орж ирж байгаагийн 11,5 мянган тонн нь алим байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

Нэг га талбайд 400-600 алимны суулгац суулгаж нэг бутнаас 15-50 кг жимс хурваж хураасан жимсээ шууд буюу дахин боловсруулалт хийн бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах бодит бололцоотой бөгөөд нийт зарцуулсан хөрөнгийг 5-6 жилд нөхөж ашигтай ажиллах тооцоог эрдэмтэд гаргасан байна.

Жимс, жимсгэнэ түүний дотроос алим, усан үзэм тариалах хөдөлгөөнийг дэмжих, түүнийг хүмүүсийн амьдрал ахуйгаа дээшлүүлэх, ажлын байр бий болгохын зэрэгцээ боловсруулах үйлдвэр байгуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотооддоо хэрэглэх, гадаад зах зээлд нийлүүлэх тодорхой бодлоготой ажиллах, хөтөлбөрийн ТЭЗҮ-г боловсруулах, хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг 2016 оноос эхлэн жил бүр орон нутгийн төсөвт төлөвлөж байх зайлшгүй шаардлага гарч байна.

Тус аймагт өнөөгийн байдлаар боловсруулах томоохон үйлдвэрүүд байхгүй, ажлын байр багатай, төрийн албан хаагчид, малчид, тариаланчид, тэтгэвэр авагчдаас бусад өрх, иргэд тогтмол орлого багатай амьдарч байна. Иймээс нийт иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд жимс жимсгэнэ хөтөлбөр чухал үүрэг гүйцэтгэх юм.

Говь-Алтай аймагт 1964 оноос эхлэн Халиун, Бигэр, Цогт, Алтай, Шарга сумуудад том, бэсрэг, давжаа алим, лийр, чаага, үхрийн нүд тариалж байсан туршлагаас үзэхэд жимс жимсгэнэ тариалах байгаль цаг уурын болон бусад нөхцөл бүрэлдсэн гэж үзэж болно.

Аймгийн Засаг даргын санаачлагаар "Алим, усан үзэм, жимс жимсгэнэ" хөтөлбөрийг 2016-2025 он хүртэл 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэн, 20000 га хүртэл талбайд алим, усан үзэм, жимс жимсгэнэ тариалж, түүнийг боловсруулах үйлдвэр байгуулах цаашдаа 2026 он гэхэд улсын хэмжээний жимс жимсгэний хэрэгцээг хангах замаар аймгийн нийт өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөрийг боловсруулав.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2026 онд Монгол улсын алим, усан үзэм бусад жимс жимсгэнийг хэрэгцээг бүрэн хангана.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ногоон эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурлан дараахь зарчмыг баримтална:

3.1 Бүтээгдэхүүний гарал үүсэл нь тодорхой, үйлдвэрлэл борлуулалтын аль ч дамжлагад стандарт, эрүүл ахуйн шаардлагыг чанд баримтлах;

3.2 Экспортын баримжаатай экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих;

3.3 Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны ололтыг ашиглах;

3.4 Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын харилцан ойлголцол, иж бүрэн түншлэлийг чухалчлах

3.5 Цаг уурын ойролцоо нөхцөлтэй, БНХАУ-ын Хами аймаг, ОХУ-ын Алтай улсын алим, усан үзэм, жимс жимсгэнэ тариалсан туршлагыг өөрийн нутаг нутагшуулах

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хөтөлбөрийн зорилго нь алим, усан үзэм, жимс жимсгэнийг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр 1 өрх 1 га талбайд тариална гэж тооцоолон 2026 онд 20000 га хүртэл талбайд тариалж, өрхийн орлогоо нэмэгдүүлэн, цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангах аймгийн нийт өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

4.1 Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.1 Алим, усан үзэм, бусад төрлийн жимс, жимсгэний аж ахуй эрхлэх хөгжүүлэх эдийн засгийн тавтай орчинг бүрдүүлэх;

4.1.2 Алим, усан үзэм бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, хураан авах, боловсруулах технологийг боловсронгуй болгох, мэргэжилтний чадавхийг сайжруулах;

4.1.3 Алим болон усан үзэм бусад жимс жимсгэнэ тариалах, боловсруулах үйлдвэр байгуулах, хөгжүүлэх санаачилгыг технологийн удирдлага, санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих замаар бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах;

4.1.4 Бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалахыг дэмжих замаар жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн зах зээлд өрсөлдөх чадварыг хөгжүүлж, импортыг бууруулах;

4.1.5 Хөтөлбөрийн ач холбогдлыг нийтэд сурталчлах, жимс, жимсгэнэ түүгээр боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 "Алим, усан үзэм бусад төрлийн жимс, жимсгэний аж ахуй эрхлэх, хөгжүүлэх эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх" зорилтын хүрээнд:

5.1.1 Алим жимс жимсгэнэ тариалах техник эдийн засгийн үндэслэлийг ШУА, ШУТИС, ХААИС, Дархан хотын ургамал газар тариалангийн хүрээлэн, Үвс аймгийн эрдэм шинжилгээний салбар хүрээлэн, Хятад улсын Хами аймаг, ОХУ-ын Алтай улс болон эрдэмтэн мэргэд, судлаачидтай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ судалгааны баг ажиллаж ТЭЗҮ, зураг төсөв боловсруулна. /Судалгааны баг ажиллуулахад эхний урьдчилсан тооцоогоор 250 сая төгрөг шаардлагатай/.

5.1.2 Орон нутагт тариалсан жимс, жимсгэний борлуулалтыг дэмжих ажлыг төр хувийн хэвшлийн ААН-үүдтэй хамтран зохион байгуулна;

5.1.3 Анх удаа алим, усан үзэм, жимсгэний тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийг гадаад дотоодын төсөл, хөтөлбөр, зээл тусламж, хөнгөлөлттэй зээлд хамруулна.

5.1.4 Жимс жимсгэний аж ахуй, хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр усалгааны далан суваг барих ажлыг ээлж дараатай хийж гүйцэтгэнэ.

5.1.5 Иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад хөнгөлөлттэй зээл олгох, тариалсан жимс, жимсгэнийг зах зээлд борлуулах үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

5.2 "Алим, усан үзэм бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, хураан авах, боловсруулах технологийг боловсронгуй болгох, мэргэжилтний чадавхийг сайжруулах" зорилтын хүрээнд:

5.2.1 Алим, усан үзэм, жимс, жимсгэний төрөл зүйлийн онцлог шинж чанарын харьцуулсан судалгааг ЭШБ-аар гүйцэтгүүлж тухайн бүс нутагт тохирсон сортыг сонгон тарьж ургуулах агротехнологи боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

5.2.2 Органик гаралтай ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис, бордоо болон алим жимс жимсгэнэ тариалах, хураан авах, хадгалах, боловсруулахад шаардагдах техник тоног төхөөрөмжийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран түншлэлийн хүрээнд зохион байгуулах.

5.2.3 Тариалсан жимсээс шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн гарган авах, хадгалах, хэрэглэх технологи, уг бүтээгдэхүүний биохимийн найрлага, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөнд эрдэм шинжилгээ, клиник судалгаа хийх шинжлэх ухааны төслүүд хэрэгжүүлэх;

5.2.4 Жимс хураах, хадгалах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологийг боловсронгуй болгож, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;

5.2.5 Алим, усан үзэм, жимс, жимсгэний чиглэлээр ажиллаж байгаа судлаач, мэргэжилтэн, үйлдвэрлэл болон жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч, сонирхогчдыг дэмжин дотоод, гадаадын мэргэжлийн сургалтад хамруулах, харилцан туршлага солилцох, тэдгээрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

5.2.6 Жимс, жимсгэний зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийг урьж, үйлдвэрлэгч, тариаланчдыг танхимын болон ажлын байран дээрх сургалтад хамруулах;

5.2.7 Алим, усан үзэм, жимс, жимсгэний чиглэлээр үйлдвэрлэл дээрээ сургалт явуулж байгаа ажил олгогчдод хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх.

5.3 "Алим болон усан үзэм тариалах боловсруулах үйлдвэр байгуулах, хөгжүүлэх санаачилгыг технологийн удирдлага, санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих замвар бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд:

5.3.1 Шилмэл сортын алим, жимс, жимсгэний суулгац үржүүлэн зах зээлд нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлттэй зээлийн нөхцөлөөр нийлүүлэх;

5.3.2 Жил бүр Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн тодорхой хувийг алим, жимс, жимсгэнэ тариалах суулгац бэлдэх, талбайг усжуулах далан сувгийг барих, засварлахад зарцуулах;

5.3.3 Хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр жимс, жимсгэний аж ахуй эрхлэх иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх;

5.3.4 Усалгаатай тариалангийн талбайд хамгаалалтын ойн зураас хэлбэрээр, худгийн дэргэд болон иргэд хувийн хашаа, талбайд алимьт дангаар нь буюу бусад жимс, хүнсний ногоотой зэрэгцүүлэн тариалах хөдөлгөөнийг өрнүүлэх;

5.3.5 Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд ургуулж байгаа ойн зурваст алим тариулах;

5.3.6 Жимс, жимсгэнэ бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах.

5.3.7 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг урамшуулан дэмжиж, үндэсний болон олон улсын түвшинд монголын газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр бүртгүүлэх арга хэмжээ авах, гадаадын зах зээл, маркетингийн судалгаа хийх;

5.3.8 Стандартын шаардлагад нийцсэн бага, дунд оарын боловсруулах үйлдвэр болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох орчин үеийн техник, технологи бүхий томоохон цогцолбор үйлдвэрийг бүсчлэн байгуулахад Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих;

5.3.9 Жимс, жимсгэнэ тариалахад шаардлагатай мэргэжилтэй ажилтныг аймаг дахь МСҮТ-д бэлтгэх.

5.4 "Бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалахыг дэмжих замаар жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн зах зээлд өрсөлдөх чадварыг хөгжүүлж, импортыг бууруулах" зорилтын хүрээнд:

5.4.1 Байгалийн жимс, жимсгэнэ, алимыг тарималжуулах, нутагшуулах, түүнийг селекцийн эх материал болгон ашиглаж сайжруулах замаар өөрийн орны байгаль цаг уурын нөхцөлд зохицсон арвин ургац бүхий сорт, дээжүүдийг бий болгох;

5.4.2 Бүс нутгийн уур амьсгалын онцлог, жимс, жимсгэнэ тариалж ирсэн уламжлалд тулгуурлан үхрийн нүд, интоор, бөөрөлзгөнө, нохойн хошуу, тошлой, өрөл, чацаргана, чавга зэрэг жимс, жимсгэнийг нутагшуулан турших, тариалахыг дэмжих;

5.4.3 Манай улсад ургах боломжтой жимс, жимсгэний мод, суулгацыг гадаад орнуудаас оруулан турших, тариалахад дэмжлэг үзүүлэх;

5.4.4 Органик жимс, жимсгэний тариалалтыг бүх талаар дэмжин Ногоон барааны тэмдэгтийг нэвтрүүлэх, жимст цэцэрлэгийг ашиглан "Ногоон аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх;

5.4.5 Алим, бусад төрлийн жимс, жимсгэний мод, бутыг ургах боломжит сумын төв суурингийн цэцэрлэг, ногоон байгууламжид тариалан цэцэрлэгжүүлэлтэд өргөн ашиглах.

5.5 "Хөтөлбөрийн ач холбогдлыг нийтэд сурталчлах, дотоодын жимс, жимсгэнэ, түүгээр боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох" зорилтын хүрээнд:

5.5.1 Жимс, жимсгэний ач холбогдол түүний зохистой хэрэглээ болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний ашигт чанарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах;

5.5.2 "Алтайн жимс" брэнд бүтээгдэхүүнийг бий болгон дотоодын болон олон улсын уулзалт, семинар, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний бага хурал, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сонирхогч орнуудад сурталчлан таниулах, хамтарч ажиллах.

5.5.3 Сургалтын байгууллагыг түшиглэн мэргэжилтэй ажилчин бэлтгэх, дотоодын жимс, жимсгэний зохистой хэрэглээг бий болгоход чиглэсэн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх;

5.5.4 Цэцэрлэг, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллын газруудад болон "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд дотоодын үйлдвэрийн стандарт, чанарын шаардлага хангасан жимс, жимсгэнэ болон тэдгээрийг боловсруулсан бүтээгдэхүүнийг өргөн хэрэглэх;

5.5.5 Алим, усан үзэм болон бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, дахин боловсруулах талаар шинжлэх ухааны байгууллагуудын судалгаа, шинжилгээний үр дүн, иргэд, аж ахуйн нэгжийн туршлага, санал санаачилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, түгээх;

5.5.6 Жимс, жимсгэнэ болон тэдгээрийг боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын дотоод, гадаадын сүлжээг бий болгох.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

"Алим, усан үзэм, жимс жимсгэнэ" хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2025он хүртэл хэрэгжүүлнэ:

6.1 I үе шат-2016-2020 он үе шатанд хөтөлбөрийг сурталчлах, алим, усан үзэм бусад жимс, жимсгэний аж ахуй эрхлэх, хөгжүүлэх эдийн засгийн орчинг сайжруулан, жилд 10000 доошгүй суулгац бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, тариалсан талбайн хэмжээг 10000 га хүртэл нэмэгдүүлнэ.

- Алим, жимс жимсгэнэ хураах ажиллагааг хөнгөөчлөх, жимсийг боловсруулах техник, технологийг боловсронгуй болгож үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр жимс, жимсгэнэ түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний баруун бүсийн улсын дотоодын хэрэгцээг хангаж маркетингийн сүлжээг бий болгоно.

6.1.1 II үе шат-2021-2026 он

Энэ үе шатанд жимс, жимсгэнэ тариалах чадавхийг сайжруулсаны үндсэн дээр алим, усан үзмийн тариалалтыг 20000 га-д хүргэн өндөр технологи бүхий боловсруулах үйлдвэрийг бүсчлэн байгуулж, олон улсын стандартын шаардлагад нийцсэн органик гарал бүхий газар зүйн заалттай, экологийн цэвэр нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, экспортод тогтвортой гаргадаг болно.

- Алим, усан үзмэ жимс, жимсгэнэ тариалах, ургац хураах, боловсруулах үйл ажиллагааг тогтмолжуулж дотоодын хэрэглээ, экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Аймгийн зөвлөл ажиллана. Аймгийн зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлнэ.

7.2 Аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орон нутагт ажиллаж буй холбогдох мэргэжлийн байгууллагын мэргэжилтэнүүд, мэргэжлийн хяналтын газрын холбогдох улсын байцаагчид, төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаач, үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон байна.

7.3 Сумдад хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг тухайн шатны Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл орж ажиллана.

7.4 Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг Аймгийн зөвлөл болон сумдын салбар зөвлөлүүд боловсруулан баталж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

7.5 Хөтөлбөрт заагдсан зарим зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

7.6 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймаг, сум нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт ирүүлэх ба ХХААГ –аас